



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Ерөнхий боловсролын арван долоо дугаар сургуулийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/080/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: ppurevlkhagva@gmail.com

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: “Төгс нотолгоо аудит” ХХК-ийн Ахлах аудитор:
Г.Цэцэгмаа
Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.21 № 25
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН АРВАН ДОЛОО
ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.АЛТАНЗАЯА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн ерөнхий боловсролын арван долоо дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн ерөнхий боловсролын арван долоо дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 128 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс дагаж мөрдөхөөр сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг 7 дугаар хавсралтаар баталж, албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 239,918.1 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

Аудитын гол асуудал

Боловсролын Ерөнхий газраас 2023 оны 12 дугаар сарын 21-ны 01/6148 албан тоотоор Аймгийн Засаг даргын тамгын газарт чиглэл хүргүүлсний дагуу ерөнхий сургуулиудад гал тогооны түрээслэгч аж ахуйн нэгжийн гэрээг дуусгавар болгож, сургуулийн хэмжээнд хоол үйлдвэрлэл үйлчилгээг үзүүлэх ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулсан байна.

Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоос 42,689.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, хүнсний түүхий эд материал, тоног төхөөрөмж, ажиллагсдын эрүүл ахуйн хувцас, аж ахуйн материалын зардалд нийт 42,275.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг тайлант онд үнэлээгүй байна.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 630 хүүхдээр тооцсон боловч 1606 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp of the State Audit Agency of Mongolia is positioned over a handwritten signature. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН УЛСЫН АУДИТ АГУУГА" (State Audit Agency of Mongolia) and "ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР" (Chief Auditor). The signature is written in black ink over the stamp.

ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>208,124,612.65</u>	<u>453,750,811.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	71,709,149.86	311,627,282.48
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	71,709,149.86	311,627,282.48
3121	Төгрөг	71,709,149.86	311,627,282.48
31211	Төрийн сангийн харилцах	71,709,149.86	311,627,282.48
35	БАРАА МАТЕРИАЛ	136,415,462.79	142,123,529.02
351	Түүхий эд материал	63,185,593.00	75,515,093.00
35110	Тусгай зориулалттай материал	63,185,593.00	75,235,093.00
35130	Эм боох материал	-	280,000.00
354	Хангамжийн материал	73,229,869.79	66,608,436.02
35410	Бичиг хэргийн материал	3,864,680.00	2,741,750.00
35420	Аж ахуйн материал	4,325,710.00	5,692,900.00
35440	Түлш, шатах тослох материал	9,969,356.27	3,874,999.99
35460	Хүнсний материал	-	599,499.00
35470	Бусад хангамжийн материал	55,070,123.52	53,699,287.03
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,442,071,648.17</u>	<u>5,671,062,340.47</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,442,071,648.17	5,671,062,340.47
392	Биет хөрөнгө	4,988,832,148.01	5,217,967,840.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,999,703,594.20	5,251,813,643.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(407,678,642.32)	(523,191,680.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	360,544,631.50	530,089,976.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(100,988,338.30)	(175,330,755.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	201,836,830.00	224,789,335.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(64,585,927.07)	(96,296,760.62)
39209	Зам, гүүр байгууламж	4,309,219.00	10,613,441.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(4,309,219.00)	(4,519,359.72)
393	Биет бус хөрөнгө	453,239,500.16	453,094,500.20
39301	Программ хангамж	1,450,000.00	1,450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,120,499.84)	(1,265,499.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	452,910,000.00	452,910,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,650,196,260.82</u>	<u>6,124,813,151.97</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,650,196,260.82</u>	<u>6,124,813,151.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,650,196,260.82	6,124,813,151.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,872,083,874.65	1,872,083,874.65
51101	Өмч: - төрийн	1,872,083,874.65	1,872,083,874.65
512	Хуримтлагдсан үр дүн	3,085,713,401.76	3,560,330,292.91
51210	Өмнөх үеийн үр дүн	3,085,713,401.76	3,085,713,401.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	474,616,891.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	692,398,984.41	692,398,984.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,650,196,260.82</u>	<u>6,124,813,151.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,036,796,636.30	3,632,208,204.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,213,132,136.30	961,845,404.30
120	Нийтлэг татварын бус орлого	1,130,278,436.30	841,155,904.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,754,310.00	241,897,428.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,116,200.00	7,702,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,638,110.00	234,195,228.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,026,385,991.00	399,350,921.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан хүлээн авсан орлого-Бараа материал	97,138,135.30	199,907,555.30
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	82,853,700.00	120,689,500.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	82,853,700.00	120,689,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,823,664,500.00	2,670,362,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,823,664,500.00	2,670,362,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,823,664,500.00	2,670,362,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,064,904,851.71	3,157,591,313.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,064,904,851.71	3,157,591,313.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,951,677,300.26	3,016,017,073.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,392,505,050.76	2,004,576,647.81
210101	Үндсэн цалин	926,338,136.76	1,196,392,137.62
210102	Нэмэгдэл	418,521,654.00	762,607,903.19
210104	Урамшуулал	47,645,260.00	45,576,607.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,287,965.73	257,005,920.36
210201	Тэтгэврийн даатгал	118,926,204.43	176,335,934.33
210202	Тэтгэмжийн даатгал	14,093,745.44	20,496,612.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,101,030.49	11,575,039.98
210204	Ажилгүйдлийн даатгал	2,738,998.23	10,859,003.30
210205	Эрүүл мэндийн даатгал	27,427,987.14	37,739,329.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,596,991.58	151,888,297.89
210301	Гэрэл, цахилгаан	35,631,032.55	43,565,913.61
210302	Түлш, халаалт	73,297,143.03	85,232,537.78
210303	Цэвэр, бохир ус	19,498,016.00	23,089,846.50
2104	Хангамж, бараа материалын зардал	10,358,000.00	18,282,746.29
210408	Бараа материал акталсны зардал	-	18,282,746.29
2105	Нормативт зардал	120,000.00	79,523,520.00
210502	Хоол, хүнс	-	79,523,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,179,250.00	133,305,664.00
210604	Урсгал засвар	26,179,250.00	133,305,664.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,086,200.00	37,553,703.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,116,200.00	7,702,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,970,000.00	29,851,503.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	205,543,842.19	333,880,573.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,570,200.00	93,527,195.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,532,190.00	18,431,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	159,441,452.19	221,921,428.70

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,227,551.45	141,574,239.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,205,700.00	121,540,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	113,205,700.00	121,540,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,851.45	20,033,739.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,851.45	20,033,739.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(151,632,341.71)	474,616,891.15
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(151,632,341.71)	474,616,891.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,913,272,510.00	3,032,949,728.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,608,010.00	362,586,928.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,754,310.00	241,897,428.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,754,310.00	241,897,428.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,116,200.00	7,702,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,638,110.00	234,195,228.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	82,853,700.00	120,689,500.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	82,853,700.00	120,689,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,823,664,500.00	2,670,362,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,823,664,500.00	2,670,362,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,823,664,500.00	2,670,362,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,826,721,926.49	2,738,968,295.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,826,721,926.49	2,738,968,295.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,713,494,375.04	2,597,394,055.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,392,505,050.76	2,004,576,647.81
210101	Үндсэн цалин	926,338,136.76	1,196,392,137.62
210102	Нэмэгдэл	418,521,654.00	762,607,903.19
210104	Урамшуулал	47,645,260.00	45,576,607.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,287,965.73	257,005,920.36
210201	Тэтгэврийн даатгал	118,926,204.43	176,335,934.33
210202	Тэтгэмжийн даатгал	14,093,745.44	20,496,612.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,101,030.49	11,575,039.98
210204	Ажилгүйдлийн даатгал	2,738,998.23	10,859,003.30
210205	Эрүүл мэндийн даатгал	27,427,987.14	37,739,329.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,299,848.55	66,655,760.11
210301	Гэрэл, цахилгаан	35,631,032.55	43,565,913.61
210303	Цэвэр, бохир ус	19,498,016.00	23,089,846.50
2105	Нормативт зардал	-	80,123,019.00
210502	Хоол, хүнс	-	80,123,019.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,532,000.00	34,000,000.00
210604	Урсгал засвар	25,532,000.00	34,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,086,200.00	37,553,703.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,116,200.00	7,702,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,970,000.00	29,851,503.21

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,783,310.00	117,479,005.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,404,110.00	98,688,605.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,379,200.00	21,602,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,227,551.45	141,574,239.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,205,700.00	121,540,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	113,205,700.00	121,540,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,851.45	20,033,739.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,851.45	20,033,739.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	86,550,583.51	293,981,432.62
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	51,251,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	51,251,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	51,251,300.00
220001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		51,251,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(54,063,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	86,550,583.51	239,918,132.62
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		71,709,149.86
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,709,149.86	311,627,282.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2024 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл	1,872,083,874.65	692,398,984.41	3,085,713,401.76	5,650,196,260.82
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,872,083,874.65	692,398,984.41	3,085,713,401.76	5,650,196,260.82
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			474,616,891.15	474,616,891.15
D09	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,872,083,874.65	692,398,984.41	3,560,330,292.91	6,124,813,151.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,947,410,800.00	2,718,934,555.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,947,410,800.00	2,718,934,555.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,810,717,600.00	2,597,394,055.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,147,636,800.00	2,004,576,647.81
210101	Үндсэн цалин	1,410,026,200.00	1,196,392,137.62
210102	Нэмэгдэл	720,749,600.00	762,607,903.19
210104	Урамшуулал	16,861,000.00	45,576,607.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	268,454,600.00	257,005,920.36
210201	Тэтгэврийн даатгал	182,549,100.00	176,335,934.33
210202	Тэтгэмжийн даатгал	21,476,400.00	20,496,612.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,738,200.00	11,575,039.98
210204	Ажилгүйдлийн даатгал	10,738,200.00	10,859,003.30
210205	Эрүүл мэндийн даатгал	42,952,700.00	37,739,329.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,689,900.00	66,655,760.11
210301	Гэрэл, цахилгаан	43,904,500.00	43,565,913.61
210303	Цэвэр, бохир ус	34,785,400.00	23,089,846.50
2105	Нормативт зардал	43,887,900.00	80,123,019.00
210502	Хоол, хүнс	43,887,900.00	80,123,019.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,000,000.00	34,000,000.00
210604	Урсгал засвар	34,000,000.00	34,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,187,300.00	37,553,703.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,703,300.00	7,702,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	53,484,000.00	29,851,503.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	176,861,100.00	117,479,005.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,258,700.00	95,876,605.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,602,400.00	21,602,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,693,200.00	121,540,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,693,200.00	121,540,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	136,693,200.00	121,540,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,767,064,100.00	2,912,260,228.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,586,535,800.00	2,670,362,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,586,535,800.00	2,670,362,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	180,528,300.00	241,897,428.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,703,300.00	7,702,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	172,825,000.00	234,195,228.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		71,709,149.86
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		311,627,282.48

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 233,972.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 233,972.4 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Тус сургууль нь 2024 оны эхний хагас жилд 45,844.3 мянган төгрөгийн нүүрсийг эд хариуцагч бараа материалын тайлан гаргаагүй, нягтлан бүртгэлд бөөн дүнгээр зарлагадсан, хэрэгцээ шаардлагад тулгуурлаж олгодоггүй, бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сургуулийн халаалтын зуух шинэчлэн засварлах ажлын 59,440.1 мянган төгрөг, сургуулийн барилгын гэмтэл засварлах ажлын 89,707.9 мянган төгрөг нийт 149,148.0 мянган төгрөгийн хөрөнгийн сайжруулалтыг капиталжуулаагүй, тусдаа хөрөнгөөр бүртгэсэн.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сургуулийн 1-р байрны цонхны дулаалга хийх, түгжээ солих засварын 38,980.1 мянган төгрөгийн зардлыг тайлант үеийн зардлаар бүртгээгүй, хөрөнгөөр бүртгэсэн байна.

Аудитаар нийт 27,984.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 6,686.9 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 3,015.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 18,282.7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,686.9 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт хүргүүлэв. Үүнд:

- Тайлант онд 61 албан хаагчийн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 5,692.1 мянган төгрөг илүү олгосон байна.
- ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсээс спортын арга хэмжээний зардалд дэмжлэг үзүүлсэн 3,000.0 мянган төгрөгийг сургуулийн захирлын 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн А/28 дугаар тушаалаар захиран зарцуулахаар албан хаагчийн харилцах дансанд ХАОАТ-ын 10% суутгаагүй шилжүүлсэн байна.
- Сургуулийн захиралд Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсролын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалыг үндэслэн 694.8 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон байна.

5.2 Албан шаардлага

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,015.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг үндэслэж, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 1,471.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна.
- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн 1,544.0

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сургуулийн захирлын 2024 оны 05 дугаар сарын 08-ны А/20 тушаалаар хагас жилийн хөрөнгийн тооллогыг 2024 оны 05 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 14-нд хооронд хөрөнгийн тооллого хийх тушаал гарсан байхад, өмч хамгаалах комиссын шийдвэргүй, 2024 оны 05 дугаар сарын 07-ны А/19 тоот захирлын тушаалаар 18,282.7 мянган төгрөгийн ном актлах тушаал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх"-гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллогоор актлах шаардлага хангахгүй цаг хугацаанд нь хийж, хөрөнгийн тооллогоор актлах шаардлагатай хөрөнгүүдийг бэлтгэн өмч хамгаалах комиссоор шийдвэрлүүлэх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ерөнхий боловсролын арван долоо дугаар сургууль	3	233.9			3	233.9	3	233.9				
Дүн	3	233.9			3	233.9	3	233.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ерөнхий боловсролын арван долоо дугаар сургууль	6	27.9	3	6.7	2	3.0	1	18.3				
Дүн	6	27.9	3	6.7	2	3.0	1	18.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	6	27.9	3	6.7	2	3.0	1	18.3		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

